



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/9/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020

Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19

Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2020.02.21 № 1-6/99
танай _____-ны № _____-т

АЛТАНШИРЭЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Т.ГАНМӨНХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2.1. Оршил

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Т.Ганмөнх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-ээс 2020 оны 01 дүгээр сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 3/12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Иргэдэд төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, оновчтой бодлого зохицуулалтаар хангахад оршино.

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “aculous” программ хангамж ашигладаг байна.

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 33 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 203,246.4 мянган төгрөгөөс тооцон 2,032.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 4,600.7 мянган төгрөгөөр тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,519.0 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	32,986.0	40,095.3	7,109.3
Үндсэн хөрөнгө	1,592,808.8	1,601,218.5	8,409.7
Нийт хөрөнгө	1,625,794.8	1,641,313.8	15,519.0
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,609,620.1	1,625,139.2	15,519.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,609,620.1	1,625,139.2	15,519.1

Авлагагүй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь мал амьтадын дансанд 7,540.0 мянган төгрөгийн малыг бүртгэсэн нь шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,409.7 мянган төгрөгөөр өссөн бөгөөд үүний 3,023.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 124,078.5 мянган төгрөгийн хөрөнгийг сумын Орон нутгийн хөгжлийн сангаас хүлээн авсан, 17,954.2 мянган төгрөгийн хөрөнгийг Грийн Энержи проспекити ХХК-аас үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Тайлант онд 9,600.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлж, 6,744.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,625,139.2 мянган төгрөг болж 15,519.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 815.1 мянган төгрөгийн бичилт хийсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газар нь 2019 онд 800.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 800.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	800.0	800.0	-	100
Нийт дүн	800.0	800.0	-	100

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 7 зориулалтад 290,766.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 289,966.6 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 800.0 мянган төгрөгийг бусад урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 288,470.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 800.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 288,470.7 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байна. /цалин хөлс болон нэмэгдэл урамшил 200,369.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 25,046.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 12,800.1 мянган төгрөг, хангамж бараа материал 18,421.8 мянган төгрөг, нормативт зардал 200.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 6,460.0 мянган төгрөг, томилолт зочны зардал 4,282.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 14,045.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 6,844.5 мянган төгрөг/ нийт дүнгээр 1,495.8 мянган төгрөг хэмнэгдэж үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,956.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 1,117.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,839.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,650.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 450.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 100.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 2,100.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 2,200.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 100.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,100.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Олгосон цалингийн урьдчилгааг буцаан суутгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу цаг хугацаанд нь, үнэн зөв ... бүртгэж тайлагнах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Үндсэн цалингийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын үндсэн цалингийн зардал “цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 114 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 15 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй буюу “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Жолоочийн цалингаар дамжуулж сар бүр малчинд 100.0 мянган төгрөгийг олгодог.

Энэ нь (үнэн зөв байдал, эрх ба үүрэг) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 “үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Хууль, дүрэм журам зөрчигдөх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйл “Туслах үйл ажиллагаа”-ийг мөрдөж ажиллах.

2 Орлогын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Байрны түрээс, усны төлбөрийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Энэ нь (үнэн зөв байдал) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн “6.2.2 жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх” 44.4 “туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг

нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ”, 44.5.1 “тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг бууруулах”, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаал “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралтын 4 “төсвийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэхээс бусад тогтмол үзүүлдэг ажил, үйлчилгээний орлого /бүртгэл, лавлагаа, үйлчилгээний төлбөр хураамж, түрээс, сургаалт, акц, сорил, баталгаажуулалт/” заалтыг зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

Хууль, дүрэм журам зөрчигдөх.

2.3 Өгсөн зөвлөмж:

Туслах үйл ажиллагааны орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн бодит байдалтай уялдуулах мөн үндсэн үйл ажиллагааны орлогыг 2021 оны төсвийн төсөлд тусгаж, батлуулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,986,022.33</u>	<u>40,095,350.30</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	32,986,022.33	40,095,350.30
354	Хангамжийн материал	32,986,022.33	32,555,350.30
35410	Бичиг хэргийн материал	275,000.00	592,200.00
35420	Аж ахуйн материал	31,636,022.33	30,963,150.30
35440	Түлш, шатах тослох материал	1,075,000.00	1,000,000.00
35600	Мал амьтад	00.00	7,540,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,576,634,145.90</u>	<u>1,585,043,857.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,576,634,145.90	1,585,043,857.40
392	Биет хөрөнгө	1,504,910,145.94	1,513,319,857.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	845,681,010.00	845,681,010.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,000,000.00	-42,275,135.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	166,138,800.00	262,298,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-66,360,552.09	-81,285,033.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	73,159,287.18	91,683,487.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,231,834.34	-45,059,689.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,400,214.98	64,427,337.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,087,063.97	-51,197,967.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	830,706,423.29	830,706,423.29
39215	Хуримтлагдсан элэгдэл	-302,496,139.11	-361,659,374.67
393	Биет бус хөрөнгө	71,723,999.96	71,723,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	73,272,500.00	73,272,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,548,500.04	-1,548,500.04
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,609,620,168.23</u>	<u>1,625,139,207.70</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,609,620,168.23</u>	<u>1,625,139,207.70</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,609,620,168.23	1,625,139,207.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,105,559,518.71	1,105,559,518.71
51101	Өмч: - төрийн	1,105,559,518.71	1,105,559,518.71
512	Хуримтлагдсан үр дүн	-165,033,471.25	-148,699,288.20
51210	Өмнөх үеийн үр дүн	-165,033,471.25	-164,218,327.67
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	15,519,039.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	669,094,120.77	668,278,977.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,609,620,168.23</u>	<u>1,625,139,207.70</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	350,641,452.00	475,597,331.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,250,397.00	170,022,583.00
120	Нийтлэг татварын бус орлого	86,250,397.00	170,022,583.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	86,250,397.00	170,022,583.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	800,000.00	800,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	85,450,397.00	169,222,583.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	264,391,055.00	305,574,748.95
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	238,835,200.00	289,966,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	238,835,200.00	289,966,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,555,855.00	15,608,148.95
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,308,634.00	9,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,247,221.00	6,208,148.95
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	481,324,220.86	460,063,073.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	481,324,220.86	460,063,073.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	476,922,672.86	455,109,986.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,245,300.00	199,938,416.00
210101	Үндсэн цалин	174,245,300.00	199,938,416.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,020,600.00	25,562,584.00
210201	Тэтгэврийн даатгал	14,624,540.00	17,331,791.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,874,737.00	1,972,733.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,455,325.00	1,577,927.00
210204	Ажилгүйдлийн даатгал	379,218.00	395,682.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,686,780.00	4,284,451.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,679,046.00	12,812,637.00
210301	Гэрэл, цахилгаан	2,322,846.00	3,228,637.00
210302	Түлш, халаалт	14,261,650.00	9,509,000.00
210303	Цэвэр, бохир ус	94,550.00	75,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	88,736,924.00	41,703,554.03
210401	Бичиг хэрэг	1,742,200.00	3,610,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,689,075.00	11,332,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,119,634.00	3,869,999.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	35,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	79,066,015.00	22,735,655.03
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,371,650.00	3,167,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	315,000.00
210604	Урсгал засвар	1,371,650.00	2,852,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,583,600.00	4,282,500.00
210702	Дотоод албан томилолт	3,583,600.00	4,282,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,445,431.00	12,198,743.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,003,634.00	10,986,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	198,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	743,600.00	607,380.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	268,197.00	215,020.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	160,000.00	154,000.00
210807	Газрын төлбөр	40,000.00	37,943.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	159,840,121.86	155,444,552.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,927,941.00	17,953,883.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	859,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	137,912,180.86	136,631,069.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,401,548.00	4,953,086.95
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	261,548.00	3,423,086.95
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	261,548.00	3,423,086.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,140,000.00	1,530,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,140,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	50,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	1,480,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-130,682,768.86	15,534,258.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	94,602,050.12	15,218.61
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	35,056,656.03	15,218.61
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	59,545,394.09	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-94,602,050.12	-15,218.61
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-225,284,818.98	15,519,039.47

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	266,706,775.00	306,374,748.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	800,000.00	800,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	800,000.00	800,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	800,000.00	800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	800,000.00	800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	265,906,775.00	305,574,748.95
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	238,835,200.00	289,966,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	238,835,200.00	289,966,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,071,575.00	15,608,148.95
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,824,354.00	9,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,247,221.00	6,208,148.95
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	266,706,775.00	303,351,748.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	266,706,775.00	303,351,748.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,305,227.00	298,486,662.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,807,900.00	200,369,700.00
210101	Үндсэн цалин	175,807,900.00	200,369,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,217,000.00	25,131,300.00
210201	Тэтгэврийн даатгал	14,144,600.00	17,492,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,754,800.00	1,909,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,427,900.00	1,527,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	353,600.00	382,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,536,100.00	3,819,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,899,946.00	12,800,137.00
210301	Гэрэл, цахилгаан	2,322,846.00	3,228,637.00
210302	Түлш, халаалт	9,404,550.00	9,496,500.00
210303	Цэвэр, бохир ус	172,550.00	75,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,625,759.00	18,421,841.00
210401	Бичиг хэрэг	2,214,200.00	3,159,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,575,675.00	10,547,342.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,119,634.00	3,878,999.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,476,050.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,200.00	716,500.00
2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,395,650.00	3,437,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,297,000.00
210604	Урсгал засвар	1,395,650.00	2,140,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,583,600.00	4,282,500.00
210702	Дотоод албан томилолт	3,583,600.00	4,282,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,647,431.00	14,045,801.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,205,634.00	12,833,458.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	230,000.00	198,000.00

	ТОГТООХ		
210803	Даатгалын үйлчилгээ	743,600.00	607,380.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	268,197.00	215,020.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	160,000.00	154,000.00
210807	Газрын төлбөр	40,000.00	37,943.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,927,941.00	19,798,383.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,927,941.00	17,953,883.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,844,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,401,548.00	4,865,086.95
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	261,548.00	3,335,086.95
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	261,548.00	3,335,086.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,140,000.00	1,530,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,140,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	50,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	1,480,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>3,023,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	3,023,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	3,023,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	3,023,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,023,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-3,023,000.00</u>

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,034,011,518.71	304,452,324.68	-57,880,606.45	1,280,583,236.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,834,182.21	2,834,182.21
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,034,011,518.71	304,452,324.68	-55,046,424.24	1,283,417,419.15
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-2,834,182.21	00.00	-2,834,182.21
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	115,061,535.85	115,061,535.85
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,105,559,518.71	669,094,120.77	-165,033,471.25	1,609,620,168.23
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,105,559,518.71	669,094,120.77	-165,033,471.25	1,609,620,168.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	815,143.58	815,143.58
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,105,559,518.71	669,094,120.77	-164,218,327.67	1,610,435,311.81
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-815,143.58	00.00	-815,143.58
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,519,039.47	15,519,039.47
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,105,559,518.71	668,278,977.19	-148,699,288.20	1,625,139,207.70

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	290,766,600.00	289,270,779.00	1,495,821.00	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	290,766,600.00	289,270,779.00	1,495,821.00	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	289,966,600.00	288,470,779.00	1,495,821.00	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,369,700.00	200,369,700.00	00.00	100.0
210101	Үндсэн цалин	200,369,700.00	200,369,700.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,046,300.00	25,046,300.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	17,407,000.00	17,407,000.00	00.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,909,800.00	1,909,800.00	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,527,900.00	1,527,900.00	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	382,000.00	382,000.00	00.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,819,600.00	3,819,600.00	00.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,819,000.00	12,800,137.00	18,863.00	99.9
210301	Гэрэл, цахилгаан	3,219,000.00	3,228,637.00	-9,637.00	100.3
210302	Түлш, халаалт	9,420,000.00	9,496,500.00	-76,500.00	100.8
210303	Цэвэр, бохир ус	180,000.00	75,000.00	105,000.00	41.7
2104	Хангамж, бараа материалын зардал	18,561,800.00	18,421,841.00	139,959.00	99.2
210401	Бичиг хэрэг	3,244,300.00	3,159,000.00	85,300.00	97.4
210402	Тээвэр, шатахуун	10,721,000.00	10,547,342.00	173,658.00	98.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,676,500.00	3,878,999.00	-202,499.00	105.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	716,500.00	83,500.00	89.6
2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,480,000.00	6,460,000.00	20,000.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,320,000.00	680,000.00	86.4
210604	Урсгал засвар	1,480,000.00	2,140,000.00	-660,000.00	144.6
2107	Томилолт, зочны зардал	5,259,700.00	4,282,500.00	977,200.00	81.4
210702	Дотоод албан томилолт	5,259,700.00	4,282,500.00	977,200.00	81.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,330,100.00	14,045,801.00	284,299.00	98.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,848,000.00	12,833,458.00	14,542.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	198,000.00	32,000.00	86.1
210803	Даатгалын үйлчилгээ	743,600.00	607,380.00	136,220.00	81.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	288,500.00	215,020.00	73,480.00	74.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	154,000.00	26,000.00	85.6

210807	Газрын төлбөр	40,000.00	37,943.00	2,057.00	94.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6900000.00	6844500.00	55,500.00	99.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,844,500.00	55,500.00	97.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	800,000.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	290,766,600.00	289,270,779.00	1,495,821.00	99.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	289,966,600.00	288,470,779.00	1,495,821.00	99.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	289,966,600.00	288,470,779.00	1,495,821.00	99.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	800,000.00	800,000.00	00.00	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	800,000.00	800,000.00	00.00	100.0

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	13,768,883.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	13,768,883.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	13,038,883.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	85,000.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	85,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	12,953,883.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	12,953,883.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	730,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	730,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	50,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	680,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	15,608,148.95
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	15,608,148.95
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	9,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	6,208,148.95